



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/29/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954

Цахим хаяг: [Khuanganm@audit.gov.mn](mailto:Khuanganm@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930

Цахим хаяг: [jenisbekh@audit.gov.mn](mailto:jenisbekh@audit.gov.mn)

Аудитор: К.Риза

Утас: 94156768

Цахим хаяг: [Kalim\\_riza@yahoo.com](mailto:Kalim_riza@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
<b>3.1 Ерөнхий зүйл.....</b>	<b>11</b>
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	15



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЛТАНЦӨГЦ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Х.ЕРМУРАТ ТАНАА

2022.02.25 № 097  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>38269122.10</u></b>	<b><u>125752370.79</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	0.00	0.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	0.00	73946490.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	73842500.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	103990.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	38269122.10	51805880.79
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	12889608.60	18141985.90
35110	Тусгай зориулалттай материал	2702000.00	3722000.00
35130	Эм боох материал	10187608.60	14419985.90
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	25379513.50	33663894.89
35410	Бичиг хэргийн материал	72000.00	0.00
35420	Аж ахуйн материал	3438900.00	7523443.62
35460	Хүнсний материал	963633.50	92339.00
35470	Бусад хангамжийн материал	20904980.00	26048112.27
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>861146503.43</u></b>	<b><u>855628343.24</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	861146503.43	855628343.24
391	Газар	0.00	0.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	858784503.43	853266343.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	879631552.52	879631552.52
39202	Хуримтлагдсан элэгдэл	-70664585.75	-88987521.95
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66577143.00	66577143.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29484434.83	-35633601.59
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	46270711.90	71207511.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-33731889.30	-39540305.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13616250.00	13616250.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13430244.11	-13604684.71
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	2362000.00	2362000.00
39301	Програм хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-550000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2362000.00	2362000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>899415625.53</u></b>	<b><u>981380714.03</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>4098164.00</u></b>	<b><u>30044682.70</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	4098164.00	30044682.70
<b>413</b>	<b>Өглөг</b>	4098164.00	30044682.70
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	222345.00	539839.40
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	3875819.00	29504843.30
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	2822250.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3875819.00	26682593.30
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>895317461.53</u></b>	<b><u>951336031.33</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	895317461.53	951336031.33

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	598778899.00	598778899.00
51101	Өмч: - төрийн	598778899.00	598778899.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>10898498.77</b>	<b>66917068.57</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	10898498.77	10898498.77
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	56018569.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	285640063.76	285640063.76
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>899415625.53</u></b>	<b><u>981380714.03</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>420,847,928.00</b>	<b>602,636,217.63</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,130,400.00</b>	<b>17,835,637.07</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	10,130,400.00	17,835,637.07
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	10,130,400.00	17,835,637.07
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,130,400.00	17,835,637.07
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>410,717,528.00</b>	<b>584,800,580.56</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	327,879,400.00	393,641,399.56
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	19,649,799.56
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	327,879,400.00	374,005,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	20,164,498.00	70,775,331.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,164,498.00	70,775,331.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	35,470,600.00	24,946,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,470,600.00	24,946,100.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	27,203,030.00	95,437,750.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	27,203,030.00	95,437,750.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>426,547,639.94</b>	<b>546,617,647.83</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>426,547,639.94</b>	<b>546,617,647.83</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	422,209,747.94	546,617,647.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	271,201,953.00	344,695,560.00
210101	Үндсэн цалин	183,084,478.00	177,397,150.00
210102	Нэмэгдэл	66,173,579.00	83,091,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	5,292,000.00
210104	Урамшуулал	21,943,896.00	78,915,310.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,664,970.00	39,567,400.00
210201	Тэтгэврийн даатгал	23,017,542.00	27,843,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,655,403.00	2,930,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,059,092.00	2,344,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	526,700.00	586,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,406,233.00	5,861,800.00

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,744,958.00	22,128,700.00
210301	Гэрэл, цахилгаан	1,250,256.00	1,572,500.00
210302	Түлш, халаалт	32,980,744.00	20,556,200.00
210303	Цэвэр, бохир ус	513,958.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,156,040.00	27,167,551.00
210401	Бичиг хэрэг	588,150.00	1,167,100.00
210402	Тээвэр, шатахуун	17,867,890.00	23,084,481.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,001,200.00	1,300,100.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	698,800.00	1,615,870.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	31,282,730.06	73,738,286.08
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,140,489.40	63,282,017.18
210502	Хоол, хүнс	5,602,440.66	8,631,268.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	539,800.00	1,825,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	853,100.00	4,247,319.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	34,000.00	3,358,319.00
210604	Урсгал засвар	819,100.00	889,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	384,850.00	720,000.00
210702	Дотоод албан томилолт	384,850.00	720,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	311,020.00	1,028,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	236,700.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	17,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	46,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	19,000.00
210807	Газрын төлбөр	27,020.00	68,100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	47,300.00	577,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	29,610,126.88	33,324,331.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,457,800.00	2,869,372.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,152,326.88	30,454,959.75
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4,337,892.00	14000
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4,337,892.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,337,892.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(5,699,711.94)</u></b>	<b><u>56,018,569.80</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(5,699,711.94)</u></b>	<b><u>56,018,569.80</u></b>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	598,778,899.00	285,640,063.76	10,898,498.77	895,317,461.53
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	598,778,899.00	285,640,063.76	10,898,498.77	895,317,461.53

D08	Тайлант үеийн үр дүн			56,018,569.80	56,018,569.80
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	598,778,899.00	285,640,063.76	66,917,068.57	951,336,031.33

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>410717528.00</b>	<b>491322281.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>410717528.00</b>	<b>491322281.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	327879400.00	374005600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	327879400.00	374005600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	20164498.00	70775331.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20164498.00	70775331.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	35470600.00	24946100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35470600.00	24946100.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	27203030.00	21595250.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	27203030.00	21595250.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>404843528.00</b>	<b>486035281.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>404843528.00</b>	<b>486035281.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>400505636.00</b>	<b>486021281.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	269010937.00	344799550.00
210101	Үндсэн цалин	182149237.00	177397150.00
210102	Нэмэгдэл	69616700.00	83171100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		5212000.00
210104	Урамшуулал	17245000.00	79019300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35554400.00	39567400.00
210201	Тэтгэврийн даатгал	25019800.00	27843800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2633700.00	2930900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2106900.00	2344700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	526700.00	586200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5267300.00	5861800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34651600.00	23177100.00
210301	Гэрэл, цахилгаан	1250256.00	1530900.00
210302	Түлш, халаалт	32655344.00	21646200.00
210303	Цэвэр, бохир ус	746000.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21868896.00	23291331.00
210401	Бичиг хэрэг	879300.00	1000000.00
210402	Тээвэр, шатахуун	18725996.00	19791231.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1082900.00	1300100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1180700.00	1200000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	33460511.00	44489700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26131161.00	33485700.00
210502	Хоол, хүнс	5324550.00	8004000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2004800.00	3000000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1729000.00	5504800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	910000.00	4565800.00
210604	Урсгал засвар	819000.00	939000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	464091.00	720000.00
210702	Дотоод албан томилолт	464091.00	720000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	311020.00	1028500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	236700.00	300000.00
210803	Даатгалын үйлчилгээ		17800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		46500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		19000.00
210807	Газрын төлбөр	27020.00	68100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	47300.00	577100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3455181.00	3442900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3455181.00	3442900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4337892.00</b>	<b>14000.00</b>
<b>2135</b>	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	14000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		14000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>5874000.00</b>	<b>5287000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>5874000.00</b>	<b>5287000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5874000.00</b>	<b>5287000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	5874000.00	5287000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5874000.00	5287000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-5874000.00</b>	<b>-5287000.00</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	397055000.00	406379636.00	491919731.00	491308281.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	397055000.00	406379636.00	491919731.00	491308281.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	397055000.00	406379636.00	491919731.00	491308281.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	266865900.00	269010937.00	345410900.00	344799550.00
210101	Үндсэн цалин	180004200.00	182149237.00	178008500.00	177397150.00
210102	Нэмэгдэл	69616700.00	69616700.00	83091100.00	83171100.00

210103	Унаа хоолны хөнгөлөлт			5292000.00	5212000.00
210104	Урамшуулал	17245000.00	17245000.00	79019300.00	79019300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35554400.00	35554400.00	39567400.00	39567400.00
210201	Тэтгэврийн даатгал	25019800.00	25019800.00	27843800.00	27843800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2633700.00	2633700.00	2930900.00	2930900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2106900.00	2106900.00	2344700.00	2344700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	526700.00	526700.00	586200.00	586200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5267300.00	5267300.00	5861800.00	5861800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	38810600.00	34651600.00	24007100.00	24007100.00
210301	Гэрэл, цахилгаан	1530900.00	1250256.00	1530900.00	1530900.00
210302	Түлш, халаалт	36265700.00	32655344.00	22476200.00	22476200.00
210303	Цэвэр, бохир ус	1014000.00	746000.00		
210304	Байрны түрээс				
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22426600.00	21868896.00	23291331.00	23291331.00
210401	Бичиг хэрэг	973300.00	879300.00	1000000.00	1000000.00
210402	Тээвэр, шатахуун	18983600.00	18725996.00	19791231.00	19791231.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1172900.00	1082900.00	1300100.00	1300100.00
210404	Ном, хэвлэл				
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1296800.00	1180700.00	1200000.00	1200000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	25880400.00	39334511.00	45889700.00	45889700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17485700.00	32005161.00	34885700.00	34885700.00
210502	Хоол, хүнс	5387000.00	5324550.00	8004000.00	8004000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3007700.00	2004800.00	3000000.00	3000000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2566000.00	1729000.00	8504800.00	8504800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1092000.00	910000.00	7565800.00	7565800.00
210604	Урсгал засвар	1474000.00	819000.00	939000.00	939000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	658300.00	464091.00	720000.00	720000.00
210702	Дотоод албан томилолт	658300.00	464091.00	720000.00	720000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	465200.00	311020.00	1028500.00	1028500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	236700.00	236700.00	300000.00	300000.00
210803	Даатгалын үйлчилгээ	17800.00		17800.00	17800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	46500.00		46500.00	46500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19000.00		19000.00	19000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	68100.00	27020.00		
210807	Газрын төлбөр			68100.00	68100.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	77100.00	47300.00	577100.00	577100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3827600.00	3455181.00	3500000.00	3499900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3827600.00	3455181.00	3500000.00	3499900.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	397055000.00	390553030.00	421158400.00	420546950.00
<b>1310</b>	<b>улсын төсвөөс САНХҮҮЖИХ</b>	327879400.00	327879400.00	374005700.00	374005600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	327879400.00	327879400.00	374005700.00	374005600.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	40284600.00	35470600.00	24946100.00	24946100.00
132001	Орон нутгийн төсвөөс	40284600.00	35470600.00	24946100.00	24946100.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	28891000.00	27203030.00	22206600.00	21595250.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	28891000.00	27203030.00	22206600.00	21595250.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	21.00	24.00	21.00	24.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	5.00	16.00	15.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	15.00	7.00	5.00	7.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>20164498.00</b>	<b>70761331.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>20164498.00</b>	<b>70761331.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	20164498.00	70761331.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2145037.00	52318000.00
210101	Үндсэн цалин	2145037.00	
210104	Урамшуулал		52318000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3500000.00	2827331.00
210401	Бичиг хэрэг		
210402	Тээвэр, шатахуун	3500000.00	2827331.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	14519461.00	12616000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14519461.00	12112000.00
210502	Хоол, хүнс		504000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.00	3000000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		3000000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	20164498.00	70761331.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	20164498.00	70761331.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20164498.00	70761331.00
--------	--	-------------	-------------

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, гэрээт аудитор К.Риза нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн №02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго нь “Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу сумын хүн амд эмнэлгийн анхны тусламж, үйлчилгээ үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгааны ажил явуулах, халдварын тархалтыг бууруулах” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд тус сургуулийн үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 426.5 сая төгрөгийн 2 хувиар буюу 8.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 82.0 сая төгрөгөөр буюу 9.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		73946.5	73946.5
Бараа материал	38269.1	51805.9	13536.8
Үндсэн хөрөнгө	861146.5	855628.3	(5518.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>899415.6</b>	<b>981380.7</b>	<b>81965.1</b>
Өр төлбөр	4098.2	30044.7	25946.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	895317.5	951336.0	56018.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>899415.6</b>	<b>981380.7</b>	<b>81965.1</b>

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэн болон эцэст үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 73.9 сая төгрөг болж өссөн нь ажилчидтай холбоотой 0.1 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас авах татаас санхүүжилтийн авлага 73.8 сая төгрөг гарсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 51.8 сая төгрөг болж 13.5 сая төгрөгөөр нэмэгдсэний дотор эм боох материал 4.2 сая төгрөгөөр, аж ахуйн материал 4.1 сая төгрөгөөр, бусад хангамжийн материалын үлдэгдэл 5.1 сая төгрөгөөр, тусгай зориулалтын материал 1.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 49.6 сая төгрөгийн эм боох материал, 14.9 сая төгрөгийн аж ахуйн материал, 20.9 сая төгрөгийн шатахуун, 7.3 сая төгрөгийн хүнсний материал, 1.1 сая төгрөгийн бичиг хэргийн зүйл, 2.0 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, бусад хангамжийн материал 1.7 мянган төгрөг зэргээр нийтдээ 98.8 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 1.8 сая төгрөгийн эм боох материал, 6.7 сая төгрөгийн аж ахуйн материал, 9.4 сая төгрөгийн бусад хангамжийн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, нийтдээ 116.5 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч, 102.8 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зохих зарлагын баримтуудыг үндэслэн зарцуулж, 0.2 сая төгрөгийн бараа материалыг акталж устгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 855.6 сая төгрөг болж 5.5 сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн хөрөнгөөр 5.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авч, аймгийн ЭМГ-аас 19.6 сая төгрөгийн үнэ бүхий ковидын эмчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авч, үндсэн хөрөнгөд 30.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өглөг дансны үлдэгдэл 30.0 сая төгрөг болж 25.9 сая төгрөгөөр өссөн нь эмийн өр 22.8 сая төгрөгөөр, ажилчидтай холбогдсон өглөг 0.3 сая төгрөгөөр, тээвэр шатахууны өглөг 2.8 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ. Оны эцэст ковидтой холбоотой 73.8 сая төгрөгийн санхүүжилтийг авч чадаагүй нь өр нэмэгдэх нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 56.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 602.6 сая төгрөг байгаа ба тайлант онд цар тахалтай холбоотой 19.6 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт хийгдсэн, үнэ төлбөргүй 17.8 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгдсэн мөн дээд шатны байгууллагаас эмч ажилчдын тэтгэмжид 70.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон, тайлант жилд цар тахалтай холбоотой олгогдох санхүүжилтээс дутуу олгогдсон 73.8 сая төгрөгийн санхүүжилтийн авлагыг тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрсөн зэргээр өмнөх оноос орлого 181.8 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос нийт дүнгээр 120.1 сая төгрөгөөр өссөн нь урьд оноос цалин нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 79.4 сая төгрөгөөр, эмийн зардал 38.2 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 7.0 төгрөгөөр өссөн, бусад бараа үйлчилгээний зардлуудын өсөлт, бууралт нөлөөлжээ. Цар тахалтай холбоотойгоор цалин, эмийн зардал, хангамж бараа материалын зардлууд өссөн байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны төсвийг 421.1 сая төгрөгөөр баталжээ.

Нийт төсвийн 374.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 24.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 22.2 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Жилийн дундуур батлагдсан төсөвт өөрчлөлт оруулаагүй ба өвчний дэгдэлттэй холбоотой зарим зардлуудыг дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 374.0 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 24.9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 21.5 сая төгрөгийн, нийтдээ 420.5 сая төгрөгийн санхүүжилт авч батлагдсан төсвийг 0.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 420.5 сая төгрөг буюу 99.7 хувьтай байна.

Нийт төсвийн 78.9 хувийг цалин, НДШ-ийн зардал, 5.7 хувийг тогтмол зардал, 4.9 хувийг хангамж бараа материалын зардал, 7.9 хувийг нормативт зардал, 0.7 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ЭМГ-аас нэмэлт санхүүжилтээр 29.9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 32.9 сая төгрөгийн, сумын ЗДТГ-аас 7.9 сая төгрөгийн нийтдээ 70.6 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэлт төсвийн дансаар хүлээн авч зарцуулан оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 14.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн данснаас Эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д заасны дагуу эмч, эрүүл мэндийн ажилтнуудын тэтгэмжид 30.6 сая төгрөгийг, урамшуулалд 21.7 сая төгрөгийг, эм боох материалд 12.1 сая төгрөгийг, тээвэр шатахууны зардалд 2.8 сая төгрөг, багаж хэрэгсэл худалдаж авахад 3.0 сая төгрөг, хоолны зардалд 0.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төв нь “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд заасан “хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, эрүүл мэндийн үйлчилгээ тэгш, хүртээмжтэй байх” зарчмын хүрээнд үйл ажиллагаа явуулж бэлэн байдлын горимоор ажилласан байна.

Тус Эрүүл мэндийн төвийн эргэлтийн эмийн сангийн 2021 оны эцсийн санхүүгийн тайлангаар оны эхэнд 7.8 сая төгрөгийн эмийн үлдэгдэлтэй, 3.5 сая төгрөгийн авлагатай байсан ба тайлант хугацаанд 65.1 сая төгрөгийн эм татан авч борлуулалт хийж, 73.7 сая

төгрөгийн үйл ажиллагааны зардал гарч 8,6 сая төгрөгийн алдагдалтайгаар тайлан гаргажээ.

Оны эцэст 8.9 сая төгрөгийн эмийн үлдэгдэлтэй, Эрүүл мэндийн төвөөс авах 10.9 сая төгрөгийн эмийн авлагатай байна. Эмийн санч нь Эрүүл мэндийн төвөөс цалин авдаг мөртлөө алдагдалтай ажилласан байна.

Эрүүл мэндийн яамны сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар баталсан “Эргэлтийн эмийн сангийн журам”-ын дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулж явуулаагүй, эмийн компаниудаас авсан падааны дагуу эмийг орлогод авч иргэдэд бэлтгэн нийлүүлэгчийн үнээр борлуулсан мэтээр тайлан гаргасан байна.

Эргэлтийн эмийн сан нь ашгийн төлөөх байгууллага учир бэлтгэн нийлүүлэгчээс авсан үнэ дээр тодорхой хувийн ашиг нэмж борлуулан ашигтай ажиллах ёстой боловч эмнэлгийн зүгээс эмийн компаниудаас авсан эмийн борлуулах үнийг тогтоож өгөөгүйгээс ирсэн эмийг хэдэн төгрөгөөр борлуулж байгаа нь тодорхой бус эмнэлгийн дотор эмийн санг давхар хариуцаж байгаа юм байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 118 мэдээллийг хугацаандаа оруулсан, 1 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр өглөг үүссэн талаархи 4.0 сая төгрөгийн мэдээллийг, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг оруулаагүй байна. Шилэн дансны мэдээллийн хэрэгжилтийн дундаж хувь 90% -тай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага үүсгэсэнтэй холбоотой албан шаардлага өгөгдөж биелэлтийг хугацаандаа ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагааг анхаарч журмын дагуу ажиллуулах шаардлагатай байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 25.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч зөвлөмж хүргүүлэв.

### **4.1 Залруулсан алдаа**

Байхгүй

### **4.2 Төлбөрийн акт**

Акт тогтоогдоогүй

### **4.3 Албан шаардлага**

Үгүй

### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Тайлагналтай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Ажилчдад тэтгэмжид олгосон 21.5 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

##### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2,14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 дэхь заалтуудыг мөрдөж, цаашид зардлын гүйлгээг өглөг дансаар дамжуулан тооцоо үүсгэж, бүртгэж тайлагнах, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах.

#### **2. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

##### **2.1. Илрүүлэлт:**

Тайлант оны шилэн дансанд мэдээлэх мэдээллээс 4.0 сая төгрөгийн өглөг үүссэн мэдээллийг оруулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 90 хувьтай байна.

##### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

### 3. Эргэлтийн эмийн сантай холбоотой асуудал

#### 2.1. Илрүүлэлт:

Сумын Эргэлтийн эмийн сан Эрүүл мэндийн яамны сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар баталсан “Эргэлтийн эмийн сангийн журам”-ын дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулж явуулаагүй байна.

#### 2.2. Өгсөн зөвлөмж:

Эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагааг Эрүүд мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар баталсан журмын дагуу зохион байгуулан ажиллуулж, орлогоороо зарлагаа нөхөж ашигтай ажиллуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төв	2	25.5							2	25.5